



Хичээлийн сэдэв: СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО



Хичээлийн зорилго



**СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО ГЭЖ ЮУ БОЛОХ, ТЭДГЭЭРИЙН
ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛАХ**



Үнэлж
дүгнэх

Асуудал
дэвшүүлэх

Харьцуулан
шинжлэх



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

- ❖ Улс төрийн шинжлэх ухаанд сонгуулийг санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явц гэж тодорхойлдог.
- ❖ Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, парламенын суудал хуваарилах арга, дүрэм журмын цогцыг **сонгуулийн тогтолцоо** гэнэ.

01 МАЖОРИТАР – ОЛОНХИЙН



02 ПРОПОРЦИОНАЛЬ – ХУВЬ ТЭНЦҮҮЛЭХ



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

01 МАЖОРИТАР ТОГТОЛЦОО ЯМАР ХЭЛБЭРҮҮДТЭЙ ВЭ?

- А. ЭНГИЙН ОЛОНХ- 50-С ДЭЭШ ХУВИЙН САНАЛ АВСАН
- В. ХАРЬЦАНГУЙ ОЛОНХ- ХАМГИЙН ОЛОН САНАЛ АВСАН
- С. ҮНЭМЛЭХҮЙ ОЛОНХ- НИЙТ САНАЛЫН $\frac{3}{4}$ БУЮУ 75 ХУВЬ, $\frac{3}{2}$ БУЮУ 66 ХУВИАС ДЭЭШ САНАЛ АВСАН НЭР ДЭВШИГЧИЙГ ЯЛСАНД ТООЦОХ АРГА

МАЖОРИТАР ТОГТОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ УЛС ОРНУУД: АНУ,
АНГЛИ, ФРАНЦ, ЭНЭТХЭГ, МЕКСИК



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

МАЖОРИТАР ТОГТОЛЦООНЫ ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?

- ✓ Энгийн ойлгомжтой
- ✓ Тогтвортой засгийн газар
- ✓ Шууд сонгох
- ✓ Тойргийн сонгогчдын хариуцлага
- ✓ Намуудыг цөөрүүлдэг

МАЖОРИТАР ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛ ЮУ ВЭ?

- Санал гээгддэг
- Цөөн төлөөллөөр олонх болдог
- Саналын жин нөлөөлөл алдагддаг
- Популистууд гарах
- Парламентч тойргийн сонгогчдоос хараат
- Нутгархаг сэтгэл зүй
- Намын сахилга хариуцлага сулардаг



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

ПРОПОРЦИОНАЛЬ ТОГТОЛЦООНЫ ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?

- ✓ Санал гээгддэггүй
- ✓ Саналын төлөөлөл алдагддаггүй
- ✓ Улс төрийн хүчний зохистой харьцаа хангагддаг
- ✓ Парламент ёс хөгжих
- ✓ Намуудын төлөвшилд сайн нөлөөтэй
- ✓ Хариуцлага хүлээх субъект тодорхой
- ✓ Улс төрийн соёл боловсролын өндөр түвшин

ПРОПОРЦИОНАЛЬ ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛ ЮУ ВЭ?



- Хэт олон сул нам бий болох
- Жижиг намууд парламентад орж ирэх
- Тогтворгүй засгийн газар
- Бие даасан нэр дэвшигчдэд халгаатай
- Намчирхах сэтгэлзүй нэмэгдэх
- Орон нутгийн төлөөлөл, ашиг сонирхлыг хангах чадвар сул
- Сонгогчдоос гишүүнд хяналт тавих боломж сул



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

ХОЛИМОГ ТОГТОЛЦОО

- ❑ Холимог тогтолцоонд өөр өөр томъёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлэн ашигладаг. Үүнд санал өгөх сонгогчид ижил байх бөгөөд төлөөлөгчдийг гол төлөв нэг мандаттай тойрог бүхий харьцангуй олонхын болон намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлэх системийг хослуулан сонгодог.



https://en.wikipedia.org/wiki/Electoral_system

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Тоон баримтыг шинжлээрэй

	Суудлын тоо	Эрэгтэй	Эмэгтэй	Систем
1990 Их хурал	420			Пропорциональ
Бага хурал	53			
1992	76	73	3	Мажоритар
1996	76	68	8	Мажоритар
2000	76	67	9	Мажоритар
2004	76	71	5	Мажоритар
2008	76	73	3	Томсгосон тойрог

2012	76	65	11	Холимог
2016	76	63	13	Мажоритар

- Улсын Их Хурлын

1992 оны сонгуульд **95,60** хувь,
1996 оны сонгуульд **92,15** хувь,
2000 оны сонгуульд **82,43** хувь,
2004 оны сонгуульд **82,00** хувь,
2008 оны сонгуульд **76,46** хувь,
2012 оны сонгуульд **67,28** хувь,
2016 оны сонгуульд **73,58** хувь нь тус тус оролцож саналаа өгчээ.

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг улс орон даяар удирдан зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй бөгөөд үйл ажиллагаагаа бие даасан, хараат бус, хамтын удирдлагын зарчмаар явуулдаг, байнгын ажиллагаатай төрийн байгууллага юм.





Дүн шинжилгээ хийж, санал сэтгэгдлээ илэрхийлээрэй.

Баримт 1.

1992 оны УИХ-ын сонгуульд МАХН нийт сонгогчдын 53 хувийн санал авсан ч парламентын суудлын 92,1 хувь буюу 70-ыг авч байсан бол бусад нам эвслүүд 47 хувийн санал авсан хэдий ч парламетэд дөнгөж 6 суудал авч байсан.

Баримт 2.

2000 оны УИХ-ын сонгуульд МАХН нийт сонгогчдын 52 хувийн санал авсан ч парламентын суудлын 94.7 хувь буюу 72-ыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 48 хувийн санал авсан хэдий ч парламентад 4 суудал авч байжээ.

Баримт 3.

2016 оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 45,69%-ийн санал авсан ч паоламентын суудлын 85,5% буюу 65-г авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдыг 54,31%-ийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ.

Аль нь сонгуулийн дийлэнх олонхийн тогтолцоог тодорхойлох вэ?

A. Улс төрийн нам нь тодорхой тойргийг төлөөлөх хүмүүсийн нэрийг дэвшүүлдэг. Сонгогдохын тулд тухайн нэр дэвшигч тойрогтоо хамгийн олон санал авах ёстой.

B. Иргэд улс төрийн намын төлөө саналаа өгдөг бөгөөд нам тус бүр нэр дэвшигчдийн жагсаал гаргадаг

C. Парламентийн суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хувиарладаг.

D. Сонгогч дэмжиж буй намынхаа нэрсийн жагсаалтын төлөө саналаа гаргана.

E. Сонгуулийн дүн гархад хувь хүн биш аль нэг нам хэдэн хувийн санал авсан нь тэргүүн зэргийн ач холбогдолтой

Аль нь сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцоог тодорхойлох вэ?

A. Улс төрийн нам нь тодорхой тойргийг төлөөлөх хүмүүсийн нэрийг дэвшүүлдэг. Сонгогдохын тулд тухайн нэр дэвшигч тойрогтоо хамгийн олон санал авах ёстой.

B. Иргэд улс төрийн намын төлөө саналаа өгдөг бөгөөд парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилдаг.

C. Сонгогчдын санал үлэмж хэмжээгээр гээгддэг.

D. Парламентын гишүүн тойргийн сонгогчдоосоо хараат байдаг.

E. Улс орны хэмжээнд цөөнхийн дэмжлэг хүлээж буй улс төрийн нам парламентын суудлын олонхийг авах тохиолдол гарч болно.